



АУДИТЫН ТАЙЛАН

Байгууллагын нэр: ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Стандарт: Үе шат, Хэлбэр
ISO 45001:2018 Анхдагч, 2-р шатны аудит, газар дээр

Аудит эхэлсэн огноо : 2022.12.21
Гэрээний дугаар: БГ-22/109

АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

| | |
|------------|----------------------------|
| ОВОГ - НЭР | Дэмбээ овогтой Дуламсүрэн |
| Утас: | 99908221 |
| И-мэйл: | Dulamsurendembee@gmail.com |

БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНАРЫН МЕНЕЖЕР

| | |
|------------|------------------------|
| ОВОГ - НЭР | Ууганбаяр Лхагважаргал |
| Утас: | +976-70115522 |
| И-мэйл: | audit@moncertf.mn |

Монгол Улс, Улаанбаатар хот 14182,
Сүхбаатар дүүрэг, 7-р хороо,
Хоймор оффис 15-р давхар #1505,
Утас: (+976) 7011 5522, Гар утас: (+976) 9908 3413
www.moncertf.mn

АГУУЛГА

| | |
|---|-----------|
| I. БАЙГУУЛЛАГА БОЛОН АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА | Хууд. 4 |
| II. ДҮГНЭЛТ | Хууд. 6 |
| 1. Менежементийн тогтолцооны талаар хураангуй | Хууд. 8 |
| 2. Менежментийн тогтолцооны онцлох хэсгүүд | Хууд 10 |
| 3. Тэргүүлэх аудиторын дүгнэлт,санал | Хууд. 12 |
| IV. ХАВСРАЛТУУД | |
| Аудитын хөтөлбөр | 3 хуудас |
| Аудитын хэрэгжүүлсэн төлөвлөгөө | 7 хуудас |
| Аудитын үр дүн | 12 хуудас |
| Нээлт хаалтын хурлын тайлан | 2 хуудас |
| Хаалтын хурлын танилцуулга | 15 хуудас |
| Техникийн хавсралт | 2 хуудас |

АУДИТЛҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

БАЙГУУЛЛАГЫН НЭР

Цус сэлбэлт судлалын үндэсний төв

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цус цусан бүтээгдэхүүн цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, олгох ажиллагаа

ХАРИЛЦАХ ХҮН

Э.Чагцалдулам, Чанар, ХЭМАБ-ын Менежер, Халдвар судлаач эмч

УТАС, И-МЭЙЛ

88098312, echagtsaa@gmail.com

ТАЙЛАНГИЙН ОГНОО

2022.12.24

ТОВЧИЛСОН ҮГС

| МТ | Менежментийн тогтолцоо | ТА | Тэргүүлэх аудитор |
|---------|---|-----------------|----------------------------|
| ЧАББОЭ | Чанар, Хөдөлмөрийн эрүүл мэнд ба аюулгүй байдал, Байгаль орчин, Эрчим хүч | А | Аудитор |
| ЧМТ | Чанарын менежментийн тогтолцоо | Д | Давуу тал |
| БОМТ | Байгаль орчны менежментийн тогтолцоо | СБ | Сайжруулалтын боломж |
| ХЭМАБМТ | Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын менежментийн тогтолцоо | Тох | Тохирлын тэмдэглэл |
| ЭХМТ | Эрчим хүчний менежментийн тогтолцоо | АХ | Анхаарах хэсэг |
| ТҮБ | Тохирлын үнэлгээний байгууллага | Ж.ҮТ эсвэл Т.ҮТ | Жижиг эсвэл Том Үл тохирол |

Нууцлалын тухай заалт: энэхүү аудитын тайлан нь нууцын зэрэглэлтэй тул түүний түгээлт нь Баталгаажуулалтын байгууллага болон Аудитлүүлэгч байгууллагаар хязгаарлагдана. Тайлан нь Тохирлын үнэлгээний байгууллагын онцгой өмч. Аливаа аудит нь байгууллагын Менежментийн тогтолцооны түүвэрлэлтэд суурилсан тул шаардлагад 100% тохирч байгаа эсэхийг баталгаажуулахгүй.

© Тохирлын үнэлгээний байгууллага эсвэл түүний өмчлөгчийн шууд зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн эсвэл бүхэлд нь хуулбарлахыг хориглоно.

I. БАЙГУУЛЛАГА БА АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА

Аудитлүүлэгч байгууллагын танилцуулга

Байгуулагдсан он:

БНМАУ-ын СНЗ-ийн 1956 оны 1-р сарын 20-ны 16 тоот тогтоолоор Улаанбаатар хотын мэс заслын больницын дэргэд эмнэлгийн байгууллагуудын бэлтгэн хадгалсан эмчилгээний цусаар хангах “Цус сольж эмчлэх газар”-ыг 4 хүний орон тоотойгоор байгуулсан.

1962 оны 9-р сарын 26-ны 505 тоот тогтоолоор “Цус сэлбэх төв станц”-ыг Улаанбаатар хотод, аймгуудад цусны салбар станцыг байгуулахаар уг тогтоолд тусгагдсан.

Эрүүл мэндийн сайдын 2007 оны 5-р сарын 23-ны 138 тоот тушаалаар “Цус сэлбэлт судлалын төв”-ийг “Цус сэлбэлт судлалын үндэсний төв” болгон өргөжүүлж, ЦССҮТ-ийн бүтэц, үйл ажиллагааны дүрмийг баталсан.

ЭМС-ын 2020 оны 09-р сарын 22-ны А/445 дугаар тушаалаар шинэ бүтцийг шинэчлэн баталж энэхүү бүтцийн дагуу үйл ажиллагааг явуулж байна.



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН БҮТЭЦ



Үйл ажиллагааны чиглэл:

ЦССҮТөв нь үндэсний хэмжээнд цусны донор элсүүлэлт, цус авах, цус цусан бүтээгдэхүүний шинжилгээ, үйлдвэрлэл, чанар аюулгүй байдал, цусны сонор сэрэмжийн тогтолцоо, цус сэлбэлтийн чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, мэргэжил аргагүйгээр хангах, стандарт заавар, арга зүйн зөвлөмж боловсруулах, мэргэжлийн дүгнэлт гаргах, цус сэлбэлтийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, сургах, судалгаа шинжилгээний ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага (тусгай мэргэжлийн төв) юм.

ЦССҮТөв нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрладаг улсын хэмжээнд цусны аюулгүй байдлыг хангах, цус сэлбэлт судлалын тусламж, үйлчилгээг улсын хэмжээнд үзүүлэх Эрүүл мэндийн яамны харьяа үндэсний хэмжээний лавлагаа төв бөгөөд Улаанбаатар хотын төрийн болон хувийн хэвшлийн 100 гаруй эмнэлгийг цус цусан бүтээгдэхүүнээр 7/24 цагаар тасралтгүй хангадаг байна. Зарим онцгой тохиолдолд хөдөө орон нутгийн эмнэлгийг захиалгат бүтээгдэхүүнээр хангадаг.

Мөн тус төв нь улсын хэмжээний гамшиг онцгой байдлын үеийн цус цусан бүтээгдэхүүний улсын нөөцийг хариуцаж ажилладаг.

Хөдөө орон нутагт 26 цусны салбар төвүүд Бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймаг сумын нэгдсэн эмнэлгийн бүтцэд хамааран үйл ажиллагаа явуулж, цус сэлбэлт судлалын нэгдсэн удирдлагаар ЦССҮТ-өөс хангаж ажиллаж байна.

Дараах үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:

- Хүн амын дунд сайн дурын авлагагүй цусны донорын үйлсийг сурталчлах чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг Монголын улаан загалмайн нийгэмлэг болон бусад төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран зохион байгуулах, донороос цус авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, олгох
- Хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл, стандарт, зөвлөмжий хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах, гүйцэтгэлийг хянах
- Чиг үүрэг, эрхэм зорилго, салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангах
- Цус сэлбэлт судлалын чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн лавлагаа шатны тусламж үзүүлэх
- Цусны донорын бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох мэдээ, тайлан, цусны донор алдаршуулах, урамшуулахтай холбоотой баримтыг цаасан болон цахим хэлбэрээр архивлах
- Цус, цусан бүтээгдэхүүн, сорьцыг улсын хилээр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах
- Улсын нөөцийн тухай хуулиар хүлээлэгсэн чиг үүргийг хэрэгжүүлэх
- Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл аюулгүй ажлын байраар хангах, тэдний мэргэжил, мэдлэг, ур чадварын түвшинг тасралтгүй дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллах
- Санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх
- Хууль тогтоомжоор олгогдсон бусад үүрэг

Байгууллагын чадавхи:

ЦССҮТ нь Улаанбаатар хотод байрлан Баянзүрх дүүрэг, Сүхбаатар дүүрэг, Дүнжингарав Цус цуглуулах төв гэсэн 3 суурин болон явуулын хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол улсын ЗГ, Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр ЦССҮТ-ийн шинэ байр 2016 онд ашиглалтанд орж техник технологийн бүрэн шинэчлэлийг хийсэн.

1. ЦССҮТ-ийн төв байр

Энд төвийн удирдлага, үндсэн болон дэмжих бүх алба, тасаг үйл ажиллагаагаа явуулж, эмнэлгүүдэд 24 цагаар цус, цусан бүтээгдэхүүн (ЦЦБ) олгодог.

2. Сүхбаатар цус цуглуулах төв

Энэ төвд цус цуглуулах, цусны бүлэг тодорхойлох үйл ажиллагаа ажлын 5 хоногт явагддаг. Мөн гамшиг, онцгой байдлын үед шинжилгээ хийх, ЦЦБ үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулах, шаардлагатай хэрэгслийн нөөц агуулах, ОБЕГ-ын хөлдөөсөн шинэ сийвэнгийн нөөцийг тус тус байрлуулж, гамшигийн үеийн нөөц төв байрладаг болно.

3. Дүнжингарав Цус цуглуулах төв

Дүнжингарав худалдааны төвийн G хэсэг байрладаг. Энэ төвд ажлын өдрүүдэд суурин хэлбэрээр цус цуглуулах үйл ажиллагаа явагддаг.

4. Цус цуглуулах хөдөлгөөнт хэлбэр

Явуулаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай урьдчилан тохиролцсоны үндсэн дээр хуваарийн дагуу ажлын байран дээр очиж явуулын хэлбэрээр цус цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулдаг.

ЦССҮТ нь нийт 70 орон тоотой ба аудит явагдах хуацаанд 68 ажилтнуудтай байна.

Бүтээгдэхүүн үйлчилгээ:

| № | Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ | Тайлбар |
|---|------------------------------|--|
| 1 | Бүтээгдэхүүн | Үндсэн 4 төрлийн цус цусан бүтээгдэхүүнийг тогтмол үйлдвэрлэдэг. 25 төрлийн цус цусан бүтээгдэхүүнийг эрүүл мэндийн байгууллагын захиалгаар үйлдэрлэн нийлүүлдэг. |
| 2 | Үйлчилгээ | Цус цусан бүтээгдэхүүнийг: <ul style="list-style-type: none"> • Цуглуулах • Лабораторийн шинжилгээ хийх • Үйлдвэрлэх • Хадгалах, тээвэрлэх • Захиалга авах, олгох |

Баталгаажуулалтанд хамрагдсан Менежментийн тогтолцооны хамрах хүрээ

Цус цусан бүтээгдэхүүн цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, олгох ажиллагаа

Баталгаажуулалтанд хамрагдсан Менежментийн тогтолцооны хамрах хүрээ (байршлууд)-ний тодорхойлолт

1. ЦССҮТ-ИЙН ТӨВ БАЙР, БЗД-ийн 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө -49,
2. СҮХБААТАР ЦУС ЦУГЛУУЛАХ ТӨВ, СБД Энхтайвны өргөн чөлөө -13

Байгууллагын үйл ажиллагаанд хамаарах дагаж мөрдөх ёстой хуулийн болон зохицуулалтын шаардлагууд, түүний нийцлийн талаар мэдээлэл

ЦССҮТөв нь цус, сийвэн цуглуулах, шинжлэх, цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, иммуногематогийн лавлах лаборатори, цус цусан бүтээгдэхүүнийг эмнэлэгт олгох ЭҮ-02/23/3022 дугаар бүхий тусгай зөвшөөрөлийн дагуу үйл ажиллагаа явуулдаг.

ОНС-МТЖ1-01 ХЭМАБ-н менежментийн тогтолцоонд гүйцэтгэлийн үнэлгээ хийх журмын дагуу хууль зохицуулалтын шаардлагыг бүртгэх, тодорхойлж, нийцлийг үнэлдэг.

Баталгаажуулалтын тэмдэг тэмдэглэгээний хэрэглээ (магадлах болон давтан аудит)

| | |
|--|--|
| Баталгаажуулалтын байгууллагын логог зааврын дагуу хэрэглэж байна. | Тийм / Үгүй / <u>Хамааралгүй</u> |
| Олон улсын стандартын байгууллагын логог зохих ёсоор хэрэглэж байна. | Тийм / Үгүй / <u>Хамааралгүй</u> |

Буруу хэрэглэж байгаа тохиолдолд тайлбар бичнэ.

Баталгаажуулалтын байгууллагад ирсэн гомдлыг хаасан байдал (магадлах болон давтан аудит):

- Гомдол ирээгүй
- Гомдлыг ирсэн (Ирсэн гомдлын тайлбар болон гомдлыг барагдуулсан тайланг хавсаргана.)

Аудитын үйл явц ISO 17021 ба ISO 19011 стандартын дагуу явагдсан болно. Үүнд:

- ХЭМАБ-ын МТ-ны аудитын багийн ахлагч, гишүүн томилогдсон;
- ХЭМАБ-ын МТ-ны аудитын хамрах хүрээ, зорилго, шалгуурыг тодорхойлсон;
- ХЭМАБ-ын МТ-ны аудитын төлөвлөгөөг боловсруулж, удирдлагатай зөвшилцсөн;
- ХЭМАБ-ын МТ-ны аудитын багийн ахлагч ба гишүүний үүргийн хуваарилалтыг хийсэн;
- ХЭМАБ-ын МТ-ны аудитын ажлын баримт бичиг (ажиглалтын хуудас, хяналтын хуудас, үл тохирлын бүртгэлийн хуудас, г.м.)-ийг урьдчилан боловсруулж бэлтгэсэн;
- Аудитын нээлтийн хурлыг хийсэн.
- Аудитын үеэр **20 ажилтнуудтай** ярилцага хийсэн:
- Аудитын үеэр МТ-ны баримт бичигт дүн шинжилгээ хийх, нотлох баримтыг цуглуулж баримтжуулсан:
- Аудитын үр дүн, дүгнэлтийг гаргаж хаалтын хурлын үеэр ЦССҮТ-ийн Ерөнхий захирал Н.Эрдэнэбаяр болон бусад удирдах ажилтнуудад танилцуулсан.
- Төлөвлөгөөнд тусгагдсан алба нэгж, ажилтнууд бүрэн хамрагдсан.
- Байгууллагын зүгээс шаардлагатай баримт бичгийг нээлттэй гаргаж өгч, аудит хийх нөхцөл бололцоогоор бүрэн хангасан.
- Байгууллагын нийт ажилтан, албан хаагчдын зүгээс аудитын багт хөндлөнгөөс нөлөөлөх, бодит байдлыг нуух, гүйвуулах, буруу ойлголт өгөх аливаа оролдлого хийгээгүй бөгөөд аудит нь хараат бус, ажил хэрэгч, найрсаг уур амьсгалтай явагдсан.

Тайлан дуусгасан огноо: 2022.12.24

II. ДҮГНЭЛТ

1. МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ТАЛААР ХУРААНГУЙ

ЦССҮТөв нь 2016 оноос дараах Менежментийн тогтолцооны стандартуудыг хэрэгжүүлж, баталгаажуулсан. Үүнд:

- 2017 онд Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлж SFCS компаниар баталгаажуулагдсан. 2020 онд давтан баталгаажуулалтанд хамрагдсан.
- 2018 онд Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо MNS OHSAS 18001:2012 стандартыг нэвтрүүлж СХГ-ын баталгаажуулалтын газраар баталгаажуулагдсан.
- 2019 онд Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлж Англи улсын Lloyd's Register Quality Assurance байгууллагаар баталгаажуулагдсан.

2020 оноос Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлж эхэлсэн.

- Аудитын үеэр илэрсэн анхаарах гол асуудлууд нь Онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний дадлага туршилт хийх болон ханган нийлүүлэлт болон гэрээт байгууллагын сонгон шалгаруулалт, гүйцэтгэлийн үнэлгээнд ХЭМАБ-ын шаардлага хангаж байгаа эсэх шалгуурыг тусгах ISO 45001:2018 стандартын шаардлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой байсан.

2023 оны Магадлан аудитын үеэр анхаарч аудит хийх асуудлууд:

- Нэгдсэн менежментийн тогтолцоонд хамаарах үүрэг хариуцлага, эрх мэдлийн хуваарилалт, оролцоо, гүйцэтгэл,
- Эрсдэл, боломжийг үнэлсэн, түүнд чиглэсэн арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжүүлэлт, үр нөлөөтэй байдлын үнэлгээ
- ХЭМАБ-ын МТ-ны зорилтууд, зорилтын төлөвлөлт, гүйцэтгэл, биелэлт
- Ажилтнуудын ХЭМАБ-ын ур чадварын шаардлага, үнэлгээ, ур чадварыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ, түүний үр нөлөөг үнэлсэн үр дүн
- Онцгой байдлын бэлэн байдал, төлөвлөгөө, хэрэгжүүлсэн арга хэмжээ, зохион байгуулсан дадлага сургалт
- Гаднаас нийлүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын хяналт, мониторинг, үнэлгээ, авсан арга хэмжээ
- ХЭМАБ-ын МТ-ны дотоод аудитын үр дүн, дүгнэлт, залруулах арга хэмжээ

ЦССҮТөвийн Менежментийн тогтолцоо нь ISO 45001:2018 стандартын шалгуурт тохирч байна.

- ХЭМАБ-ын МТ-ны үйл явц, үйл ажиллагаа, нь байгууллагын дүрэм журам, шаардлагуудтай тохирч байна.
- Аудитын ажиллагааг газар дээр хийсэн бөгөөд байгууллагын хамт олон идэвхтэй оролцлоо. Аудитын үйл явцад аливаа хүндрэл гараагүй.

Аудитын үр дүнд үндэслэн МонСертф ХХК-ийн баталгаажуулалтын зөвлөлд Баталгаажуулалтын гэрчилгээ олгох саналыг тавьж байна.

Аудитын зорилгод хүрснийг баталгаажуулах

| |
|--|
| Аудитаар шалгагдсан менежментийн тогтолцоо нь аудитын шалгуурт нийцэж байгаа эсэх (тухайлбал, Дотоод аудит ба удирдлагын дүн шинжилгээ). Менежментийн тогтолцоо нийцэж байна уу? Тийм <input checked="" type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> |
| Аудитаар шалгагдсан МТ нь хуулийн, зохицуулалтын болон гэрээний шаардлагад нийцэх чадварыг үнэлэх. Менежментийн тогтолцоо нь чадамжтай юу? Тийм <input checked="" type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> |
| Аудитаар шалгагдсан Менежментийн тогтолцоо нь зорилгодоо хүрэх үр нөлөөтэй байдлыг үнэлэх. МТнь үр нөлөөтэй байна уу? Тийм <input checked="" type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> |
| Аудитаар шалгагдсан Менежментийн тогтолцооны хэрэгжүүлсэн сайжруулалтаар нь чадамжийг үнэлэх. Менежментийн тогтолцооны сайжруулалтыг олж тогтоосон уу? Тийм <input checked="" type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> |
| Үйл ажиллагаа, үйл явцууд, бүтэгдэхүүнүүд нь Менежментийн тогтолцооны шаардлага болон журмуудтай тохирч байгаа эсэхийг тодорхойлох. Тохирол нь тогтоогдсон уу? Тийм <input checked="" type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> |

Үгүй гэж хариулсан тохиолдолд аудитын үр дүнгийн хүснэгтэнд дүгнэлтийн талаар дэлгэрэнгүй тайлбар оруулна.

Алсын зайны аудит үр дүнтэй, зорилгодоо хүрсэн: Хамааралгүй

- ТИЙМ
- ҮГҮЙ, тайлбар бичнэ үү:

Хамааралгүй

Аудитын төлөвлөгөөнд гарсан өөрчлөлт:

Төлөвлөгөөнд өөрчлөлт гараагүй. Төлөвлөгөөний дагуу хийгдсэн.

Аудитын хөтөлбөрт санал болгох өөрчлөлтүүд:

Байхгүй

2. МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ОНЦЛОХ ХЭСГҮҮД

ХЭМАБ-ын МТ-ны ISO 45001:2018 стандартын нийт 32 шаардлагаар үнэлэхэд:

- давуу тал -2,
- сайжруулалтын боломж -8,
- тохирол -20,
- анхаарах хэсэг –2
- жижиг үл тохирол-0,
- том үл тохирол- 0 гэсэн үр дүнг дор танилцуулж байна.

БАЙГУУЛЛАГЫН ДАВУУ ТАЛУУД:

1) Удирдлагын манлайлал:

Ерөнхий захирал ХЭМАБ-ын МТ-ны чиглэлээр МАНЛАЙЛАЛ ба ҮҮРЭГ АМЛАЛТ авч, гарын үсэг зурсан. Энэхүү амлалтанд ISO 45001:2018 стандартын 5.1 бүлгийн шаардлагыг хангаж байна.

ХЭМАБ хариуцсан ажилтныг болон ХЭМАБ-ын зөвлөлийн үйл ажиллагааг дэмжиж ажилладаг.

ХЭМАБ-ын МТ-нд ISO 45001:2015 стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөх үйлчилгээ, сургалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн, манлайлан оролцдог. Удирдах ажилтнууд болон нийт ажилтнуудад стандартын шаардлага, ач холбогдлыг ойлгуулж хэрэгжүүлэхийг дэмжиж ажиллаж байна.

2) ХЭМАБ, МТ-ны нөөц, хангалт:

ХЭМАБ-ын МТ-г бүрдүүлэх, нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, байнгын сайжруулахад шаардлагатай нөөцийг тодорхойлж, хангаж ажилладаг.

Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалтанд сүүлийн үеийн техник технологийг нэвтрүүлэн, автоматжуулсан.

Ажилтнууд болон үйлчлүүлэгч нарын аюулгүй, тав тухтай ажиллах, үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлсэн.

САЙЖРУУЛАЛТЫН БОЛОМЖ:

1) 4.4 ХЭМАБ-ын үйл явц

ХЭМАБ-ын үйл явцын нэгтгэл зургийг боловсруулж батлуулсан байна. Энэхүү зураглал дээр тусгагдсан удирдах үйл явц, үндсэн үйл явц, туслах үйл явц дээр бичигдсэн үйл явцуудыг тодорхойлон орц, гарц, баримтжуулсан мэдээллийн дугаарын мэдээллийг, хариуцах эзнийг тодорхойлох, ХЭМАБ-н аюул, эрсдлийг тодорхой тэмдэглэх

2) 5.3 Үүрэг хариуцлага

Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтонд ХЭМАБ-ын үүрэг хариуцлагыг дурдсан боловч хэт ерөнхий байна. Цаашид байгууллагын бүх түвшинд ХЭМАБ-ын МТнд хамаарах ажил, үүрэг хариуцлага, эрх мэдлийг хуваарилж, томилох ба мэдээлэх

3) 6.1.2 Аюулыг тодорхойлох, эрсдэл, боломжийг үнэлэх

ЦССҮТ-ийн эрсдэлээс сэргийлэх, бууруулах 2022 оны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. 12 сард тайлан гаргахаар төлөвлөсөн, одоогоор төлөвлөгөөний гүйцэтгэл болон авсан арга хэмжээний үр нөлөөтэй байдлыг үнэлээгүй.

Эрсдэл бууруулах арга хэмжээний гүйцэтгэл болон үр нөлөөтэй байдлыг үнэлэх, дүн шинжилгээ хийх, аюултай тохиолдол, эрсдлийн үнэлгээний талаар хамаарах ажилтнуудад мэдээлэн танилцуулах

4) 6.2 ХЭМАБ-ын зорилт, төлөвлөлт

Чанар, ХЭМАБ-ын бодлого, 7 зорилт тодорхойлсон. Зорилтууд хэмжигдэхүйц бус байгаа бөгөөд 6 зорилтын биелэлт нь 100% гүйцэтгэлтэй гэж тайлагнасан.

Цаашид ХЭМАБ-ын МТ-г байнга сайжруулахын тулд холбогдох алба нэгж, чиг үүргийн түвшинд ХЭМАБ-ын зорилтуудыг тодорхойлох, төлөвлөгөөг зорилтыг биелүүлэхэд чиглүүлж, уялдаатай төлөвлөн хэрэгжүүлж ажиллах

5) 7.2 Чадамж

Ажилтнуудын ур чадварыг төгссөн сургууль, мэрэгжлийн диплом, ХАБЭА болон ISO 45001:2018 стандартын сургалтанд хамрагдсан гэрчилгээ, сургалтын дараах мэдлэг шалгах тестийн дүн зэргээр үнэлж байгаа ч албан тушаалын зэрэглэл, чиг үүргийн байдлаар ХЭМАБ-ын ур чадварын шаардлагыг тодорхойлоогүй байна.

Иймд нийт ажилтнуудад байх чадамжийн шаардлагыг тодорхойлж, чадамжийн түвшинг үнэлэн, сайжруулах арга хэмжээг авч байх.

6) 7.5 Баримтжуулсан мэдээлэл

Төвийн хэмжээнд 55 журамд дүн шинжилгээ хийхэд, хүчингүй болгох 7, нэгтгэх 4, сайжруулах 36, хэвээр үлдээх 8 журам байна гэж үзсэн. 2022.11.22-нд журмуудыг шинээр болон шинэчлэн боловсруулах төлөвлөгөө гарган, түүний дагуу ажиллаж байна.

Зарим бүртгэл, маягтууд баримт бичгийн кодгүй, гарын үсэг, огноо тавигдаагүй байгаа тул цаашид хөтөлж хадгадах баримтжуулсан мэдээллийн хөтлөлт, баримтжуулалтыг сайжруулах

7) 9.2 Дотоод аудит

2022.2.24-нд 2022 оны Дотоод аудитын хөтөлбөр батлагдсан боловч хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлээгүй. 5 сард 4.1-10.3, 8 сард 4.4 бүлгээр хийнэ гэсэн ч хэрэгжээгүй.

Дотоод аудитыг ISO 45001:2018 стандартын бүх шаардлагаар хийж, ХЭМАБ-ын МТ-г үнэлэн, дотоод аудитын мөрөөр залруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн, МТ-г сайжруулах

8) 10.2 Аюултай тохиолдол, үл тохирол, залруулах арга хэмжээ

2022 онд гарсан тохиолдлуудыг эмнэлзүйн болон эмнэлзүйн бус тохиолдлууд гэж ангилан дотооддоо болон eburtgel.moh.gov.mn системд бүртгэсэн ч 2 бүртгэл ижил бус байна.

2022.9.1-нд бүртгэгдсэн тохиолдол/үл тохиролд хийсэн дүн шинжилгээ хийсэн.

Цаашид тохиолдол, үл тохирлыг хэрхэн тодорхойлох, хаана яаж бүртгэхийг тодорхой болгож журамд оруулах, шалтгааныг судлан бүртгэх ажлыг системтэйгээр хийх, авсан залруулах арга хэмжээний үр дүнтэй байдалд дүн шинжилгээ хийх, нийт ажилтнуудад мэдээлэх

БАЙГУУЛЛАГЫН СУЛ ТАЛУУД БУЮУ АНХААРАХ ХЭСЭГ:

1) 8.1.4 Худалдан авалт, гэрээтийн хяналт

Ханган нийлүүлэгч болон гэрээт байгууллагын сонгон шалгаруулалт, гүйцэтгэлийн үнэлгээнд ХЭМАБ-ын шаардлага хангаж байгаа эсэх шалгуурыг тусган, хэрэгжүүлэх, арга хэмжээ авч ажиллах

2) 8.2 Онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжэ

ОБ-ын төлөвлөгөөнд тодотгол хийх, батлуулах ажлыг яаралтай хийх, гамшгийн үед ажиллах төлөвлөгөөг турших

ҮЛ ТОХИРОЛ: Илрээгүй

3. АУДИТЫН ҮР ДҮН БА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН САНАЛ

Одоогийн аудитын үр дүнг тоогоор

| ДАВУУ ТАЛ | САЙЖРУУЛАЛТЫН БОЛОМЖ | АНХААРАХ ХЭСЭГ | | ЖИЖИГ ҮЛ ТОХИРОЛ | | ТОМ ҮЛ ТОХИРОЛ | |
|-----------|----------------------|--------------------|--------------------|--------------------|--------------------|--------------------|--------------------|
| | | Өмнөх жилийн аудит | Энэ удаагийн аудит | Өмнөх жилийн аудит | Энэ удаагийн аудит | Өмнөх жилийн аудит | Энэ удаагийн аудит |
| 2 | 8 | | 2 | | 0 | | 0 |

Тэмдэглэл: Анхаарах хэсэг болон жижиг ҮТ-г дараагийн аудитын төлөвлөгөөнд шалгахаар оруулна. Том ҮТ-г нэмэлт аудитаар хянаж шалгана (бичиг баримтын эсвэл газар дээр нь).

АУДИТЫН БАГИЙН САНАЛ

А. Аудитын төрөл:

| | |
|-------------------------------------|-------------------------|
| <input checked="" type="checkbox"/> | Анхдагч баталгаажуулалт |
| <input type="checkbox"/> | Магадлан 1 |
| <input type="checkbox"/> | Магадлан 2 |
| <input type="checkbox"/> | Шилжсэн аудит |
| <input type="checkbox"/> | Дахин баталгаажуулалт |
| <input type="checkbox"/> | Бусад |



В. Санал:

| | |
|-------------------------------------|---|
| <input checked="" type="checkbox"/> | Гэрчилгээ олгох |
| <input type="checkbox"/> | Гэрчилгээг хадгалах |
| <input type="checkbox"/> | ҮТ-г шийдвэрлэсэн байх хүртэл гэрчилгээг түтгэлзүүлэх |
| <input type="checkbox"/> | Гэрчилгээг хүчингүй болгох |
| <input type="checkbox"/> | Аудитын дараа нэмэлт ажиллагаа явуулах |
| <input type="checkbox"/> | Одоо байгаа гэрчилгээг өөрчлөх (Хүчинтэй байх хугацаа өөрчлөлгүй гэрчилгээний хамрах хүрээг өөрчлөх, бүртгэлийн дугаар өөрчлөх) |
| | Бусад |

С. Шалтгаан:

| | |
|-------------------------------------|--|
| <input checked="" type="checkbox"/> | ЧМТ, БОМТ, ХЭМАБМТ нь холбогдох стандартын шаардлагад тохирч байна. <i>Баяр хүргэе! Тэргүүлэх аудитор нь дээр дурдсан нотолгоон дээр үндэслэн <u>гэрчилгээ олгох</u> (хадгалуулах) саналыг дэвшүүлж байна.</i> |
| <input type="checkbox"/> | Менежментийн тогтолцоо нь хэдийгээр жижиг үл тохиролтой боловч стандартын шаардлагыг хангаж байна: <i>Баяр хүргэе! Тэргүүлэх аудитор дээр дурдсан нотолгоо дээр үндэслэн гэрчилгээ олгох саналыг дэвшүүлж байгаа боловч үл тохирлуудыг залруулах ажлын төлөвлөгөөг аудит дууссанаас хойш 14 хоногийн дотор ирүүлэх шаардлагатай. Залруулах ажлын гүйцэтгэлийг, аудитын үеэр олж тогтоосон анхаарах хэсгийн хамтаар дараа жилийн аудитад магадлан шалгана.</i> |
| <input type="checkbox"/> | Том үл тохирол илэрсэн: <i>Оаудитын үеэр том үл тохирол илэрсэн тул баталгаажуулалтын гэрчилгээ олгох саналыг одоогийн нехцэлд санал болгохгүй, Том үл тохирлыг 60 өдрийн</i> |

| | |
|--------------------------|---|
| | дотор залруулсан тохиолдолд газар дээр аудитыг үргэлжлүүлэн хийх боломжтой. Хэрвээ энэ хугацаанд залруулаагүй тохиолдолд дахин анхдагч үнэлгээ хийгдэнэ. |
| <input type="checkbox"/> | Санал болгохгүй: Байгууллага одоогийн нөхцөл байдалд баталгаажуулалтын гэрчилгээ олгох боломжгүй байна. Дахин анхдагч үнэлгээ товлож бүтнээр нь хийх шаардлагатай. Гарсан үл тохирол бүр дээр шалтгаан, үр дагаварын анализ хийж цаашдын ажлуудаа төлөвлөх шаардлагатай. |

| | |
|------------------------------------|--|
| АУДИТЫН ТАЙЛАНГ : | |
| Бичсэн Тэргүүлэх аудитор : | Дэмбээ овогтой Дуламсүрэн |
| Дуусгасан огноо: | 2022.12.24 |
| Гарын үсэг |  |
| ТҮБ-с хянаж баталсан: | Баталгаажуулалтын газрын дарга Б.Энхтөгс |
| Баталсан огноо: | 2023.01.16 |
| Гарын үсэг |  |
| Хүлээн авч зөвшөөрсөн Үйлчлүүлэгч: | |
| Зөвшөөрсөн огноо: | |
| Гарын үсэг | |

III. ХАВСРАЛТУУД

1. Аудитын хөтөлбөр
2. Аудитын хэрэгжүүлсэн төлөвлөгөө
3. Аудитын үр дүн
4. Нээлт хаалтын хурлын тайлан
5. Хаалтын хурлын танилцуулга
6. Техникийн хавсралт